



## МОНГОЛ – ЯПОНЫ ХАМТЫН АЖИЛЛАГАА ХОЁРДУГААР ЧУУЛГАН БОЛЛОО

Монгол-Япон улсуудын татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгүүдээс хамтран хоёр орны татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ эрхлэж буй компаниудын хоорондын харилцаа холбоог өргөжүүлэх харилцан туршлага солилцох зорилготой Монгол-Японы хамтын ажиллагааны хоёрдугаар чуулганыг зургаадугаар сарын 26, 27-нд Улаанбаатар хотод зохион байгууллаа.

Энэхүү чуулганы ач холбогдол нь татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээг 70 жил хэрэгжүүлж хөгжүүлж ирсэн Япон улсын туршлагаас судлах, өөрийн орны татварын мэргэшсэн зөвлөхүүдийг дадлагажуулах хөтөлбөрт хамруулах, хоёр орны бизнес эрхлэгчдэд санхүү, татварын цогц үйлчилгээг хүртээмжтэй хүргэх замаар тэдгээрийн ирээдүйн санхүү, татварын эрсдэлээс нь сэргийлэх, бизнесийн үнэн зөв, бодит зөвлөгөө мэдээллээр хангах үндэсийг бүрдүүлэх явдал юм.



Чуулганы үеэр “Монгол Улсын татварын мэргэшсэн зөвлөхийн тогтолцоо”, “Япон улсын татварын бүртгэлийн систем, програмын танилцуулга” сэдэвт илтгэлүүд тавигдаж, ТМЗ нийгэмлэгийн гишүүнээр элсэх журмыг танилцуулж, хоёр орны ТМЗ компаниуд цаашид хамтран ажиллах хүрээ чиглэлийн талаар санал солилцлоо.



Уг арга хэмжээнд Япон улсаас 11 төлөөлөгч, татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний 6 компани, Монголын татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний 20 гаруй компаний төлөөлөл, ТМЗ нийгэмлэгийн гишүүд оролцсон. Монгол, Японы татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний дээрх зургаан компани хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурсан бөгөөд ирсэн төлөөлөгчдөөс Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийн “Дэмжигч гишүүн”-ээр долоон хүн элссэн юм.

2014 оны 6 сарын 27-нд Япон улсын төлөөлөгчид “ТМЗ нийгэмлэг”, “Мэжик Чойс” ХХК, “Интоор Финанс” ХХК-иар зочилж үйл ажиллагаатай нь танилцаж, туршлага солилцлоо.



“Тод Такс ТМЗ” ХХК-ийн захирал У.Оюунаа “Ишигэ Тошиказү ТМЗ” ХК-ийн захирал Ишигэ Тошиказү



“Монгол Такс ТМЗ” ХХК-ийн захирал Х.Тунгалагмаа  
“Като НББ” ХХК-ийн захирал Като Такехито



“Лидер Финанс” ХХК-ийн захирал Ү.Галмандах  
“Ред Саппорт” ХК-ийн захирал Ватанабэ Тадаши



“Хүлэг консалтинг ТМЗ” ХХК-ийн захирал Д.Лхасва-Очир  
“Игараши Акихито НББ” ХХК-ийн захирал Игараши Акихито



“Интегретед Финансиал Сервис” ХХК-ийн захирал А.Тамир  
“Анбишенс” ХК-ийн захирал Сүзүки Шинжи



“Интоор Финанс” ХХК-ийн захирал Г.Үүрийнтуяа  
“Танака Хидэки ТМЗ” ХК-ийн захирал Танака Хидэки

